



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2021 он 10 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар ХЭГ/2538

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.ДОРЖХАНД ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний хомсдол үүссэн асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: 6 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021512467

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2021 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн
ХТ/1558 дугаар албан бичгийн хавсралт

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Т.ДОРЖХАНДААС МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

Асуулга 1.Шатахууны хомсдолтой байдал үүсэхэд хоёр улсын Засгийн газар хооронд аливаа нэг үл ойлголцол байгаа эсэх, хойд хөршийн шатахуун, эрчим хүчний эх үүсвэрийн хамаарлаас гарах бодит төлөвлөгөө, авч хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ байгаа эсэх:

Өнөөгийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100% импортоор хангаж байгаа ба нийт импортын 95 хувийг ОХУ, 5 хувийг БНХАУ тус тус эзэлж байна.

ОХУ-аас шатахуун худалдан авах үйл ажиллагааг 2018 онд “Роснефть” НХН болон Монголын шатахуун импортлогч компаниудын хооронд байгуулсан 2023 он хүртэл шатахуун нийлүүлэх урт хугацааны гэрээгээр зохицуулдаг.

Энэхүү гэрээгээр шатахууны сар бүрийн захиалгын хамгийн бага хэмжээг тогтоож, захиалгын дагуу нийлүүлэхээр тохиролцсон ба тус гэрээнд АИ-92 шатахууны минимум хэмжээг сард 28 мянган тонн байхаар тусгасан.

Мөн худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны протоколын 4.2-т “Импортлогч компаниудын хүсэлт болгосон хэмжээгээр газрын тосны бүтээгдэхүүн, тэр дундаа 5 бүлгийн /Евро-5/ шатахууныг ОХУ-аас нийлүүлэх асуудлаар талууд үргэлжлүүлэн харилцан дэмжлэг үзүүлнэ” гэж тусгагдсан.

Роснефть компаниас сар бүрийн 26-ны өдөр дараа сард нийлүүлэх шатахууны хил үнийг ирүүлдэг бөгөөд шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүд тус үнэд үндэслэн дараа сард худалдан авах шатахууны захиалгын хэмжээг нийлүүлэгч талд хүргүүлэн харилцан баталгаажуулдаг.

ОХУ-аас манай улсад нийлүүлэх шатахууны хангамж, нийлүүлэлт 2021 оны 08 дугаар сарыг дуустал хэвийн явагдаж байсан.

Харин ОХУ-аас нийлүүлэх газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт доголдсон, БНХАУ-аас газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэн авчрахад хүндрэл гарсан нь хөрш орнуудтай хөгжүүлж буй харилцаанд үл ойлголцол, асуудал үүссэнээс болоогүй болно.

Тухайлбал, ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд И.К.Азизов Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэтэй 9 дүгээр сарын 22-ны өдөр уулзах үеэрээ үүссэн нөхцөл байдалд оросын талаас улс төрийн шалтгаангүй болохыг нотолсон.

Роснефть компани Ангарскийн газрын тос боловсруулах үйлдвэрт ээлжит техникийн засвар, үйлчилгээ хийгдэж байгаа шалтгаанаар 09 дүгээр сард Монгол Улсад нийлүүлэх Аи-92 автобензиний захиалгыг 50 орчим хувиар бууруулж байгаа

талаар мэдээлэл ирүүлсэн хэдий ч зөвхөн 7750 тонн буюу сард нийлүүлэх минимум хэмжээний 30 хувийг нийлүүлж, дахин нийлүүлэх боломжгүй талаар 2021 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр мэдэгдсэн.

Оросын талын энэхүү шийдвэр нь манай улсын шатахууны хангамжийн тогтвортой байдалд нөлөөлж, 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар шатахууны импорт өмнөх сартай харьцуулахад 52 хувиар буурч, тасалдал, хомсдол үүсэх нөхцөл байдалд хүргэсэн.

Манай улсын Аи-92 автобензиний сарын дундаж хэрэглээ 38 мянга орчим тонн байдаг бөгөөд дээрх нөхцөл байдалтай холбогдуулан шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүд хэрэглээнд үүсч буй Аи-92 автобензиний зөрүүг БНХАУ-аас хангахаар төлөвлөн, тус улсын Петрочайна интернэшнл компаниас худалдан авах захиалгыг 8 дугаар сарын сүүлчээр өгсөн байна.

БНХАУ-аас газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэн авчрахад хүндрэл үүссэн нь юуны өмнө манай аж ахуйн нэгжүүд худалдан авах бүтээгдэхүүнээ Хятадын төмөр замаар тээвэрлэх төлөвлөгөөнд тусгуулаагүй байсантай холбоотой.

Иймд Хятад улсаас импортлох шатахууны төмөр замын тээврийг төмөр замын хуваарьт оруулах, тээвэрлэлтийг саадгүй, шуурхай гүйцэтгэх, Замын-Үүд боомтоор яаралтай татан авах асуудлаар Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол Улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яам болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар шатахууны хангамж, нийлүүлэлтэд үүсээд байгаа нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох шийдвэр гарсан.

Үүний үр дүнд Хятадын тал Монгол Улс руу шатахуун тээвэрлэх 200 вагоныг тус улсын 2021 оны 09 дүгээр сарын төмөр замын хуваарьт нэмэлтээр оруулж, шуурхай хамтран ажилласан.

ГХЯ-ны зүгээс мөн хөрш орнуудад суугаа ДТГ-уудад газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлттэй холбоотой судалгааг тогтмол хийж, манай холбогдох байгууллагуудыг шинэ мэдээллээр тогтмол хангаж байх чиглэлийг өгсөн болно.

Засгийн газрын 2017 оны 2-р сарын 17-ны өдрийн “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай” 59 дүгээр тогтоолоор Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил /EPC-1/-ын ерөнхий гүйцэтгэгч Энэтхэгийн “JMC Projects India” компани, МГТБҮ ТӨХХК хооронд 2020.10.13-ны өдөр гэрээг байгуулж, 2021 оны 3 сард төслийн талбайд ажлыг эхлүүлээд байна. Энэ ажлын хүрээнд үйлдвэрийн иргэний барилга байгууламжууд болох угтах байр-1, угтах байр-2, лаборатори, анхан тусламжийн төв, хоолны газар, сургалтын төв, агуулах, засварын цех, гал унтраах ангийн барилгын зураг төслийн ажил нь 90%-ийн гүйцэтгэлтэй, барилга угсралтын ажил хянагдсан зураг төслийн

дагуу 28%-тай үргэлжилж байгаа бөгөөд газар шорооны ажил бүрэн дуусаж бүтээцийн ажлууд явагдаж байна. Бүтээн байгуулалтад шаардлагатай бараа материалын худалдан авалт 68% -тай явагдаж байна.

Үйлдвэрийн зам талбайн үерийн ус зайлуулах суваг шуудуу болон цуглуулах савны газар шороо, сувагчлалын суурь бетоны ажил 50%-ийн гүйцэтгэлтэй байна. 2021 оны 9-р сарын байдлаар үйлдвэрийн талбайд Энэтхэг улсын 126 иргэн, дотоодын 10 компанийн 364 инженер техникийн ажилтнууд ажиллаж байна.

Үйлдвэрийн технологийн усыг Бор хөөврийн говиос хангахаар шийдвэрлэсний дагуу 11 худаг, 100м³-ын ус цуглуулагч сав, ус дамжуулах 88 км урттай хоолой, өргөх насос станцын ажил 23%-ийн гүйцэтгэлтэй, үйлдвэрийн талбайд байрлах 30000м³ багтаамжтай усан сангийн барилгын ажил 25%-ийн гүйцэтгэлтэй байна.

Үйлдвэрийн анхдагч процессийн болон дагалдах байгууламжууд, үйлдвэрийн хангамжийн системийг барьж байгуулах ажил /EPC-2/-ын ерөнхий гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах тендерийг 2021.04.13-нд зарласан бөгөөд тендер хүлээн авах хугацааг цар тахлын нөхцөл байдал, ажлын өргөн цар хүрээ болон тендерт оролцогч компаниудын хүсэлтийг харгалзан 2 удаа сунгаж, тендерийг 2021 оны 10 дугаар сард хүлээн авахаар ажиллаж байна.

Үйлдвэрийн цахилгаан станцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил (EPC-3)-ын хүрээнд 35 МВт хүчин чадалтай 2 ширхэг уурын генератор, 17,5 МВт-ын 2 ширхэг уурын турбин бүхий шингэн түлшээр ажиллах цахилгаан станцыг барьж байгуулах юм. Ажлын ерөнхий гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах тендерийг 2021.05.20-нд зарласан бөгөөд энэ оны 2021 оны 10 дугаар сард хүлээн авахаар ажиллаж байна.

Лицензтэй байгууламж худалдан авалт (EPC-4)-ын хүрээнд лиценз эзэмшигчдээс ирүүлсэн тендерийн техникийн хэсгийг хянах, үнэлэх ажил эцсийн шатанд явагдаж байгаа бөгөөд техникийн шаардлага хангасан тендерийн үнийн саналыг нээх ажил эхлээд байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэг хэсэг болох үйлдвэрийн ажилчдын 550 айлын хотхоны эхний ээлжийн орон сууцны барилга угсралтын ажил 90%-тай байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах бүтээн байгуулалтын ажлын нэг хэсэг болох боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах Дорнод аймгийн Матад сумаас, Дорноговь аймгийн Алтанширээ сум дахь үйлдвэрийн байршил хүртэлх хүртэлх 560 орчим километр түүхий тос дамжуулах хоолой байгуулах төслийн ажлыг эхлүүлээд байна. УУХҮЯ, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК дээр “Түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах” Үнэлгээний хороог байгуулж, мэргэжил, санхүүгийн чадавхтай олон улсын компаниудыг тендерт оролцуулах зорилгоор урьдчилсан сонголтын урилгын зарыг АНУ-ын “Gulf Publishing” компанийн “Pipeline and Gas Journal” сэтгүүл болон олон улсын газрын тосны сайтуудад нийтлүүлсэн. Урьдчилсан сонголтод 9 улсын 22 компани оролцох хүсэлтээ ирүүлснээс шалгуур хангасан 15 компанид тендерийн баримт бичгийг 2021.04.23-ны өдөр хүргүүлсэн. Тендерт оролцогч компаниуд тендер ирүүлэх хугацааг сунгах хүсэлтийг удаа дараа гаргаж байгаа тул тендер хүлээн авах

хугацааг нийт 4 удаа сунгаж, 2021 оны 10 дугаар сарын сүүлээр тендерийг нээхээр бэлтгэж байна.

Асуулга 2.БНХАУ-аас татан авах ачаа тээвэр, ложистикийн хүндрэл болон нүүрс, бусад түүхий эдийн экспортод тавигдаж буй хориг хязгаарлалтуудын ард Засгийн газар хоорондын үл ойлголцол байгаа эсэх, цаашид экспорт хийх сувгаа нэмэгдүүлж, хил, гааль, ачаа тээвэрлэлт, боомтын үйл ажиллагааг өргөжүүлсэн экспортыг ядаж ковидын өмнөх түвшинд хүргэх бодит төлөвлөгөө байгаа эсэх талаар:

Замын-Үүд боомт:

Автотээвэр: Манай улсад Коронавирусын халдварын цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор БНХАУ-ын талаас 2020 оны 11 дүгээр сарын сүүлээс ачаа тээвэрлэлтэд хязгаарлалт хийж эхэлсэн бөгөөд БНХАУ-ын талаас тавьсан шаардлагын дагуу Эрээний талд тодорхой тооны монгол жолооч нарыг байрлуулж, хоёр улсын хилийн "0" цэгт тээврийн хэрэгслийг солилцох байдлаар улс хоорондын ачаа тээвэрлэлтийг явуулж байна.

Тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, бусад төрийн байгууллагууд хамтран хятадын талтай идэвхтэй яриа хэлэлцээ өрнүүлсний үр дүнд 2021 оны 08 дугаар сараас эхлэн БНХАУ руу гарах автомашины тоог 100 байсныг 145 болгон нэмэгдүүлсэн. Үүнээс гадна 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн БНХАУ руу экспортын нүүрс тээвэрлэж гарсан автомашинд импортын ачаа ачих асуудлыг хятадын талтай тохирч хэрэгжүүлж эхэлсэн.

Одоогийн байдлаар БНХАУ-ын Эрээний гаалийн бүсэд 32 монгол жолооч байрлаж байгаа бөгөөд эдгээр жолооч нарын дараагийн ээлж болох 70 жолоочийг хятадын тал руу нэвтрүүлэхээр Замын-Үүд суманд тусгаарласан боловч 4 жолоочоос Коронавирусын халдварын цар тахал илэрсэн тул үлдсэн 66 жолоочийг 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр хятадын тал руу нэвтрүүлсэн. Гэвч БНХАУ-ын талд хийсэн шинжилгээгээр эдгээр 66 жолоочийн 9 жолоочоос Коронавирусын халдвар илэрсэн тул эдгээр 66 жолоочийг бүгдийг нь Монгол Улс руу буцаасан.

Иймээс Замын-Үүд боомтоор хийгдэж буй ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор одоо хэрэгжиж буй тээвэр зохион байгуулалттай зэрэгцүүлэн хилийн бүсэд чирэгч болон чиргүүлийг солих замаар тээвэрлэлтийг явуулах, мөн хилийн "0" цэгт чингэлгийг автомашинаас автомашинд шилжүүлэн ачих асуудлыг БНХАУ-ын талтай тохирохоор ажиллаж байна. Холбогдох журмын төслийг боловсруулан холбогдох газруудад хүргүүлээд байна.

БНХАУ-ын Эрээн хотод Коронавирусын халдварын цар тахлын тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотойгоор 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс хятадын тал Эрээн боомтоор нэг ч автомашин оруулаагүй байна.

Төмөр замын тээвэр: Коронавируст халдварын цар тахлын нөхцөл байдлын улмаас Замын-Үүд авто замын боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн тоо буурч, БНХАУ-ын Эрээн хотод Монгол Улсын импортын ачаа ихээр нэмэгдэх болсонтой холбогдуулан эдгээр ачааг яаралтай татан авах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

- Хятадын талд өргөн царигаар хүлээлгэн өгч буй экспортын галт тэрэгний ачааг буулган хоосон буцаж буй вагонд ачаа ачуулан улсын хилээр оруулж ирэх асуудлаар хятадын талтай хэлэлцээ хийж, Эрээн өртөөн дээрээс 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн кранаар ачих боломжтой ачаануудыг өдөрт дунджаар 25 вагонд ачиж эхэлсэн. Энэхүү ажлын үр дүнд Эрээн өртөөн дээр 2021 оны 08 дугаар сард 887 вагон /нарийн царигаар-210, өргөн царигаар-677/, 9 дүгээр сард нийт 1007 /нарийн царигаар-136, өргөн царигаар-871/ вагон ачигдсан бөгөөд улсын хилээр 6 дугаар сараас эхлэн Эрээн өртөөнд ачигдсан нийт 2172 /нарийн царигаар-542, өргөн царигаар-1630/ вагон хүлээж авсан.

- БНХАУ-аас автомашинаар оруулж ирсэн ачааг Замын-Үүд боомт дээр төмөр замын вагонд шилжүүлэн ачих ажиллагааг гүйцэтгэхэд цар тахлын халдвар хамгааллын дэглэмтэй холбогдуулан ачигчийн хомстол үүссэн нөхцөлд зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 08-ны өдрүүдэд дайчлан, нийт 661 вагон буюу 30944.1 тонн ачааг ачуулж, тээвэрлэлтийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангуулж ажилласан.

Эрээн өртөөнд ачигдан Замын-Үүд өртөөнд орж ирсэн импортын ачааны мэдээ

Огноо	Хүлээн авсан вагон тоо		
	Нарийн царигаар	Өргөн царигаар	Бүгд
2021 оны 06 дугаар сард	284	25	309
2021 оны 07 дугаар сард	10	238	248
2021 оны 08 дугаар сард	112	496	608
2021 оны 09 дүгээр сард	136	871	1007
Бүгд өссөн дүнгээр:	542	1630	2172

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлт:

Өнөөдрийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлт Монгол, Хятадын Баянхошуу, Ханги, Гашуунсухайт, Шивээхүрэн зэрэг 4 боомтоор явагдаж байна. Булган боомтоор хийгдэж буй тээвэрлэлтийг орон нутгийн удирдлагууд түр зогсоосон байдалтай байгаа бөгөөд ойрын хугацаанд тээвэрлэлтийг эхлүүлэхээр ажиллаж байна.

Гашуунсухайт боомт: Уул уурхайн экспортын үйл ажиллагаанд оролцогч жолооч, тухайн бүс нутагт үйлчилгээ үзүүлж буй иргэдийг Коронавирусын эсрэг дархлаажуулалтын вакцинд хамруулах ажлыг 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс эхэлсэн бөгөөд Цагаан хад суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэд, нүүрс тээврийн жолооч, нийт 18600 орчим иргэдийг Коронавирусын эсрэг вакцины 1, 2-р тунд хамруулсан. Мөн уул уурхайн ажилчид, жолооч нарыг вакцины 3-р тунд хамруулах ажил эхэлсэн бөгөөд 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Өмнөговь аймагт нийт 8884 хүн 3-р тунд хамрагдсан бөгөөд үүнээс "Оюутолгой" ХХК-ийн 3006 ажилтан, Гашуунсухайт боомтод 256 хүнд хамрагдсан байна.

Цагаан хад суурьшлын бүсийг Коронавирусын халдваргүй ногоон бүс байлгах зорилгоор Гашуунсухайт боомтод ажиллаж буй төрийн 3 байгууллагын 99 албан хаагч Зэвсэгт хүчний 50 цэрэгтэй хамтран 23 цэгт хяналтын цэг байгуулан 24 цагаар хяналт тавин ажиллаж байна.

Мөн нүүрс тээврийн жолооч нараас БНХАУ-ын Ганцмод боомтод хийж буй шинжилгээгээр Коронавирусын халдвар илэрч нүүрсний тээвэрлэлт зогсох тохиолдол цөөнгүй гарсантай холбоотойгоор Зам, тээврийн хөгжлийн яам, Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа, Гашуунсухайт боомтын зөвлөл, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ хамтран Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2021.09.12-ны А/275 дугаар захирамжаар баталсан түр журмын дагуу жолооч нарыг 40 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй "Битүүмжлэгдсэн баг"-ийн зохион байгуулалтад оруулан нүүрсний тээвэрлэлтэд ажиллуулж байна. Энэхүү битүүмжлэгдсэн багийн зохион байгуулалтын онцлог нь хэрэв битүүмжлэгдсэн багийн 1 жолоочоос Коронавирусын халдвар илэрсэн тохиолдолд тухайн багийн бүрэлдэхүүнийг бүгдийг нь Цагаанхад суурьшлын бүсээс гаргаж, дахин 28 хоногийн хугацаанд Цагаанхад суурьшлын бүсийн гадна тусгаарлах арга хэмжээг авч байна. 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Цагаанхад суурьшлын бүсэд 124 битүүмжлэгдсэн багийн 3402 жолооч байгаа бөгөөд Гашуунсухайт боомтоор өдөрт 250-310 нүүрс, 60-75 зэсийн баяжмал ачсан автомашин хилээр нэвтэрч байна.

Нүүрсний экспортын тээврийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 185 дугаар тогтоолын дагуу Гашуунсухайт боомтод чингэлэг тээврийн терминал байгуулан ашиглалтад оруулсан бөгөөд одоогийн явагдаж буй тээвэрлэлттэй зэрэгцүүлэн уг терминалаар дамжуулан нүүрсийг чингэлэгт тээвэрлэх юм. Үүний тулд Гашуунсухайт-Ганцмод боомтод чингэлэг тээврийн тусгай гарц гаргах асуудлаар хятадын талтай яриа хэлэлцээ хийгдэж байна.

Шивээхүрэн боомтын хувьд нүүрсний тээвэрлэлт 13 аж ахуйн нэгжийн 220 жолооч, тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэж байгаа бөгөөд өдөрт тухайн боомтоор 170-190 нүүрс ачаатай тээврийн хэрэгсэл хилээр нэвтэрч байна. Түүнчлэн 2021 оны 09 оны 16-ны өдрөөс эхлэн 40 чингэлэг тээврийн хэрэгслийг дундын бүсэд солилцож эхлээд байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көчянтай 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хийсэн цахим уулзалтын дүнд хятадын талаас Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Цагаанхад дахь гаалийн хяналтын бүсэд хуримтлагдсан нүүрсийг татан авах ажлыг эрчимжүүлэхээ мэдэгдсэн. Энэ хүрээнд 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэвтрэх нүүрс тээврийн машины тоо тодорхой хэмжээгээр нэмэгдэж, өдөрт ачаатай хилээр нэвтрэх автомашины тоо 400-д хүрээд байна.

-----oOo-----